

Агуулга

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	10
<i>3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ.....</i>	<i>10</i>
<i>3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл</i>	<i>10</i>
<i>3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....</i>	<i>10</i>
<i>3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....</i>	<i>10</i>
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
9. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ.....	24
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ	25

Зургийн жагсаалт

Зураг 1. Талбайн байршлын тойм зураг.	5
Зураг 2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэгүүд	12

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол.....	4
Хүснэгт 2. Жилд ажиллах хоног	5
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	13
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15
Хүснэгт 5. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	16
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	20
Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22
Хүснэгт 10. Менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлагнах хуваарь	24
Хүснэгт 11. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	25

Хавсралт материалын жагсаалт

Хавсралт 1 Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтууд	
Хавсралт 2 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл	
Хавсралт 3 Улсын бүртгэлийн гэрчилгээ	
Хавсралт 4 БОМТ-ний биеллэтийн дүгнэлтийн хуудас	
Хавсралт 5 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний дэсгэр зураг	

Оршил

Төв аймгийн Заамар сум, Хайлааст багийн нутагт орших Бумбат-3 нэртэй 612.67 гектар талбайд ашигт малтмал ашиглах MV-020483 тоот тусгай зөвшөөрлийг “Юбиксолюшн” ХХК-аас 2023 оны 06 сарын 15-ний өдрийн 197 тоот шийдвэрээр 9011075082 тоот улсын бүртгэлийн дугаартай “Гурвантамга” ХХК-д шилжүүлэн авсан байдаг.

Уг төслийн Техник эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) “Лордмайн прожект” ХХК боловсруулж, 2024 оны 10-р сард Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна. “Гурвантамга” ХХК-ийн Бумбат-3 нэртэй алтны шороон ордыг ил аргаар төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 58 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасан аргачлал, БОАЖ-ын сайдын 2019 онд баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” болон ТЭЗҮ, 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 12/3721 тоот байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэн боловсруулсан болно.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг байгаль орчны мэргэжлийн байгууллага Шүрэн завъяа ХХК-ийн судлаачид, инженер техникийн ажилчид боловсруулан, 2025 онд батлагдсан байна.

БОМТ боловсруулах аргачлал:

“Санжидын ам, Халзангийн ам” алтны шороон ордын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, эрсдэлийг тооцон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тогтоогдсон ажлуудыг цаг тухай бүрд зардлыг төсөвлөн зайлшгүй авах дараах арга хэмжээнүүдийг дагаж ажиллав.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнд тавих үндсэн шаардлага, байгалийн үндсэн бүсээс хамаарах агротехникийн шаардлага, ургамлын нөхөн сэргээлтийн үе шатууд, тарих ургамлуудыг сонгох болон нөхөн сэргэсэн газрыг хүн, мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах, нөхөн сэргээж буй газрын хөрс, ургамлын хяналт шинжилгээнд тавих шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн.

Тус төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлсэн юм.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


“Санжидын ам, Халзангийн ам” хэсгийн алтны шороон орд нь засаг захиргааны хувьд MV-020483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлд хамаарах Бумбат-3 талбайн Санжидын ам, Халзангийн ам нэртэй хэсгүүд нь Төв аймгийн Заамар сумын нутагт, Улаанбаатар хотоос баруун тийш 227 км, Булган аймгийн төвөөс зүүн урд зүгт 158 км, Заамар сумаас баруун хойш 35 км-т оршино. Тус талбай нь Монгол орны байр зүйн зургийн М-48-138-р хавтгайд байрлана.

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицол

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
Газрын солбицол нь: М-48-138					
MV-020483 (612.67 га)	2016-03-04	15	1	104° 36' 01.02"	48° 19' 41.82"
			2	104° 36' 01"	48° 18' 01.82"
			3	104° 35' 28.84"	48° 18' 01.82"
			4	104° 35' 28.77"	48° 18' 10.22"
			5	104° 35' 28.29"	48° 18' 10.22"
			6	104° 35' 28.21"	48° 18' 19.29"
			7	104° 35' 23.36"	48° 18' 19.26"
			8	104° 35' 23.32"	48° 18' 25.74"
			9	104° 35' 18.46"	48° 18' 25.73"
			10	104° 35' 18.49"	48° 18' 24.11"
			11	104° 35' 16.06"	48° 18' 24.09"
			12	104° 35' 16.03"	48° 18' 27.33"
			13	104° 35' 13.06"	48° 18' 27.32"
			14	104° 35' 13.56"	48° 18' 32.18"
			15	104° 35' 08.71"	48° 18' 32.17"
			16	104° 35' 08.68"	48° 18' 32.41"
			17	104° 34' 56.56"	48° 18' 35.35"
			18	104° 34' 56.53"	48° 18' 38.59"
			19	104° 34' 37.11"	48° 18' 38.52"
			20	104° 34' 37.08"	48° 18' 41.77"
			21	104° 34' 27.39"	48° 18' 41.72"
			22	104° 34' 27.36"	48° 18' 44.97"
			23	104° 34' 15.22"	48° 18' 44.91"
			24	104° 34' 15.19"	48° 18' 48.15"
			25	104° 34' 07.91"	48° 18' 48.12"
			26	104° 34' 07.83"	48° 18' 57.85"
			27	104° 34' 00.55"	48° 18' 57.82"
			28	104° 34' 0.053"	48° 19' 01.05"
			29	104° 33' 55.07"	48° 19' 01.03"
			30	104° 33' 55.57"	48° 19' 13.98"
			31	104° 33' 43.43"	48° 19' 13.93"
			32	104° 33' 43.35"	48° 19' 23.64"
			33	104° 33' 33.64"	48° 19' 23.61"
			34	104° 33' 33.57"	48° 19' 30.08"
			35	104° 33' 26.29"	48° 19' 30.05"
			36	104° 33' 26.22"	48° 19' 38.15"

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
			37	104° 33' 16.51"	48° 19' 38.11"
			38	104° 33' 16.46"	48° 19' 41.82"

Судалгаа явуулсан талбай нь бүс нутгийн хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт, Заамарын нуруу, Туул голын ай сав газарт дэд бүтцийн тааламжтай нөхцөлд байрладагаараа онцлогтой.



Зураг 1. Талбайн байрилын тойм зураг

Нөөцийн тооцоо:

Алтны нөөцийн зэргийг Уул Уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11-ний өдөр баталсан “Ашигт малтмалын нөөц баялагийн ангилал”-ын түр зааварын дагуу “Бумбат-3” нэртэй талбай дахь Санжидын ам, Халзангийн ам шороон ордын алтны геологийн нөөцийг В+С зэргээр тооцсон болно.

Тус ордын нөөц нь Санжидын ам ба Халзангийн ам гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Санжидын ам: Тус хэсгийн нөөц нь газрын гадаргаас 9.2-16.4 м-ийн гүнд байрлах ба бодитой (В) зэргээр батлагдсан 3 блок, боломжтой (С) зэргээр батлагдсан 2 блокоос бүрдэнэ.

Халзангийн ам: Тус хэсгийн нөөц 3-н давхрааснаас бүрдэнэ. Дээд давхраас газрын гадаргаас дунджаар 4.4 м-ийн гүнд, дунд давхраас газрын гадаргаас дунджаар 28.8 м-ийн гүнд, доод давхраас 59.5 м-ийн гүнд байрлана. Халзангийн амны хэсгийн нөөц нь бодитой (В) зэргээр батлагдсан 7 блок, боломжтой (С) зэргээр батлагдсан 6 блокоос бүрдэнэ.

2025 онд явагдах уулын ажил, ажиллах горим:

Ажиллах горим. Уурхайн ажиллах горимыг 2025 оны уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, ордын ашиглалтын нөхцөл зэргээс хамааруулан дулааны улирлын 8 сар буюу 240 хоногийн хугацаанд, өдөрт 8-10 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллуулахаар төлөвлөөд байна. Уурхай нь 2-р сараас эхлэн уурхайн бэлтгэл ажлууд болон үржил шимт хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж, 3-р сарын 1-нээс 10-р сарыг дуустал ажиллахаар төлөвлөв. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Харин улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амрахаар төлөвлөсөн.

Хүснэгт 2. Жилд ажиллах хоног

Үзүүлэлт	2025 онд
Жилийн хуанлийн хоног	365 хоног
Жилд ажиллах хоног	240 хоног
Амралт, баяр ёслолын өдрүүд	2 хоног
Урсгал засвар хийх өдрүүд	4 хоног
Цаг агаарын хүндрэл тооцох өдрүүд	4 хоног
Жилийн бодит ажиллах хоног	230 хоног
Элс угаах ажлын хоног	230 хоног
Ээлжийн тоо	2 ээлж
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	8-10 цаг

2025 онд явагдах уулын ажил:

2025 онд ордын Санжидын ам ордын С-1, В-2, В-3, В-4, В-5, С-5 гэсэн блокууд олборлолтонд өртөхөөр байна. Энэ үед уурхайн урд дунджаар 570 м, өргөн 160 м, гүн 15 м байх бөгөөд уурхай 5.16 га талбайг хамарч байна. Халзангийн амны дээд давхаргын С-1, В-2, В-3, С-4, дунд давхаргын С-5, В-6, В-7, С-8 гэсэн блок олборлолтонд өртөхөөр байна. Энэ үед уурхайн урт дунджаар 580 м, өргөн 140 м, гүн 29.0 м байх бөгөөд уурхай 8.8 га талбайг хамарч байна. Тус онд дээрх блокуудаас нийт 1564.99 мян.м³ хөрс хуулж, 84.95 мян.м³ элс олборлон баяжуулж дунджаар 374 мг/м³-ийн агуулгатай байна.

Үржил шимт хөрс хуулалт:

Үржил шимт хөрсийг хуулахдаа хайгуулын шугамын дагуу баруун урдаас зүүн хойд зүгт 0.3м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж, экскаватор-автосамосвалын хослолоор уурхайн баруун талд салхины нөмөр газар тусгайлан сонгосон талбайд тээвэрлэн овоолно. Үржил шимт хөрсний овоолгыг 3-5 м өндрөөр байгуулж, ашиглалтын явцад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр

шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай зэрэг гүйцэтгэх боломжтой байхаар төлөвлөв.

Хөрсний дотоод овоолго:

Талбайн үржил шимт хөрсийг хуулсаны дараа Санжидын ам ордын В-4 блокийн хөрсний чулуулгийг экскаватор-автосамосвалын хослолоор хуулан дотоод овоолго хийх замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөв. Хөрс хуулалтын ажлын догол мөргөцгийн өндөр нь ажиллах тоног төхөөрөмжийн үзүүлэлтээс шалтгаалан 5м байна.

Элс олборлолтын ажил:

Элсийг уурхайн мөргөцөгөөс экскаватор-автосамосвалын хослолоор олборлон уурхайгаас баруун урд зүгт 3.5 км зайд дахь элс угаан баяжуулах хэсгийн дэргэдэх элсний түр овоолго руу тээвэрлэн угаан баяжуулахаар төлөвлөв. Мөн угаасан хоосон чулуулгийг эргүүлэн тээвэрлэж уурхайд нөхөн дүүргэлт хийхээр төлөвлөж байна.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө:

Энэ оны уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг улирал бүрд гүйцэтгэх уулын ажлын эцсийн байдлын хүрээнд хийгдсэн уулын ажлын тооцоо, зургыг үндэслэн боловсруулав. Уулын ажлын тооцоонд технологийн шаардлагын дагуу ургамлын шимт бүрхэвчтэй хөрсийг тухайн районы үзүүлэлтээр 0.2 м-ээр хуулна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хангай-Хэнтийн уулархаг муж нь уулс хоорондын Туул голын хөндий, гадаргуугаас 900-1000 м үнэмлэхүй өндөрт байрлана. Талбай нь Туул голын баруун эргийн дагуу байрлах Заамарын нуруунд харьяалагдах бөгөөд энэ нурууны хамгийн өндөр нь 1816 м хүрдэг боловч Заамарын нурууны ихэнх оргилуудын үнэмлэхүй өндөр нь 1500- 1700 м юм. MV-020483 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Бумбат-3 талбай нь Хэнтийн нурууны салбар болох Заамарын нуруу, Шандын нуруу түүний салбар уулсын баруун хойд жигүүр, Туул голын ай сав газарт, голын хөндийнхөө баруун гар талд байрлана. Заамарын нуруу 1500-1815.5 м /Цагаан уул/ үнэмлэхүй өндөртэй, уулсын хажуу нь олон тооны гол, горхи, жалгаар хэрчигдсэн, 25-300-ын налуутай /заримдаа 400/, харьцангуй өндөршилт нь 300-500 м. Уул нуруудыг зааглаж буй хотгор, хөндийнүүд 950-1100 м өндөрлөгт байрлана. Туул голын ай савд багтах ба Туул гол нь Орхон голын баруун цутгал бөгөөд 600 км урттай, голдирлын өргөн 30-100 м, гүн нь 0.5-2.6 м хүрдэг.

Талбайд ойрхон хамгийн өндөр цэг гэвэл талбайгаас урагш 14 км зайнд байрлах Заамар уул 1815.7 м, мөн талбайгаас зүүн урагш 5 км зайнд байрлах Шандын нурууны оргил Халзан уул 1714.7 м зэрэг болно. Харин талбайн хамгийн нам доор цэгүүд нь гэвэл Туул голын хөндий 900 950 м болох ба тусгай зөвшөөрлийн талбайн хамгийн нам доор цэг нь Хайлаастын хөндийн доод хэсэг, талбайн баруун хойд хэсэгт байх Санжидын амны жалга 1050.0 м болно.

Газрын гадаргуугийн хувьд Судалгааны талбайд дунд зэрэг, нам уулсын, дов гүвээрхэг, тэгшрэлийн гэсэн 4 төрлийн гадаргуу ялгагддаг. Дунд зэргийн уулсын гадаргуу нь Захцаг уулын өмнөд хэсгийн салбар уулсаар илэрхийлэгдэх агаад 1600-1816.2 м үнэмлэхүй өндөрлөгтэй, харьцангуй өндөршилт нь 300-500 м байдаг ба голчлон доод эрт төрмөлийн настай чулуулаг тархсан. Намхан уулсын гадаргуу нь үндсэндээ энэ нутаг дэвсгэрийн үнэн төрх бөгөөд дунд уулсыг эмжээрлэн хүрээлсэн байдалтайгаар Захцаг уулын салбар хэсгүүдээр тохиолдох 1200-1300 м үнэмлэхүй өндөрлөгтэй, харьцангуй өндөршилт нь 100-150 м доод эрт төрмөлийн боржинлогуудаар төлөөлөгдөнө. Дов гүвээрхэг гадаргууд уулс хоорондын хотгорт болон голын хөндийн хэсгээр тохиолдох 1000-1200 м үнэмлэхүй өндөрлөгтэй, 100 м-ийн харьцангуй өндөршилттэй газрууд хамаарна. Тэгш гадаргуу болох 950-1000 м үнэмлэхүй өндөрлөгтэй уулс хоорондын хотгор, Заамарын хөндийд Цэрдийн настай нүүрс агуулсан хурдас, Плиоцены болон Дөрөвдөгчийн насны сэвсгэр хурдас тархсан байдгаараа онцлогтой.

Усан сүлжээний хувьд Дүүргийн хэмжээн дэх хамгийн том гол нь Орхон голын баруун цутгал болох 600 км орчим урттай, 1-4 км өргөн хөндий бүхий Туул гол юм. Голын голдирол нь тохойрол, тахирлалт ихтэй, олон тооны хар ус, жижиг аралтай бөгөөд өргөн нь 30-100 м, гүн нь 0.5-2.6 м зарим газраа 3.5 м, урсгалын хурд 0.3-11 м/сек, хөндийн хэвгий нь 0.001-0.002. Туул голын зүүн цутгал болох Цагаан булаг, Тосон зэрэг хөндийнүүд нь байнгын урсгал устай байдаг. Талбайн хойд талын аманд Баян гол нэртэй жижиг гол (3600 л/ц) урсан Туул голд цутгадаг.

Цаг уурын хувьд Эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь 28°C, хамгийн хүйтэн нь 1-р сард -37°, хамгийн халуун нь 7-р сард +32-35° хүрдэг. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367.3 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80 % нь зуны улиралд бороо байдлаар ордог. Өвлийн улиралд 5-25 см цасан бүрхүүл тогтон, улирлын хөлдөлтийн гүн 2.5 м хүрдэг ба голчлон баруун хойноос 5 10 м/сек хурдтай салхи салхилдаг. Заримдаа 20 м/сек хүрэх удаа бий.

Хөрс ургамалын хувьд Хар, хар хүрэн ойн үсэнцэр хөрстэй, газар тариаланг эрчимтэй чиглэлээр хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг бөгөөд бүх нутгийн 60 шахам хувийг малын бэлчээрт ашиглах боломжтой байсан бол уул уурхай эрчимжсэний дараагаар одоо 25-30 %-ийг мал аж ахуйн бэлчээрт ашиглаж байна.

Хүн амын хувьд хүн амын суурьшилт нягт биш, голчлон мал аж ахуй болон газар тариалан эрхэлдэг халхчууд амьдардаг ба Заамар сумын хэмжээнд 3000 орчим хүн суурьшдаг. Тус дүүрэг нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй бүс нутаг юм.

Дэд бүтцийн хувьд хамгийн ойр орших улсын чанартай авто зам нь Улаанбаатар – Булганы сайжруулсан зам бөгөөд Туулын гүүрнээс орд хүртэл 22 км зайтай байдаг. Суурин газраас Заамар сумын төв, алт олборлох үйлдвэрийн суурин (Шижир алт) байх бөгөөд эдгээр газрууд нь Улаанбаатар - Дархан - Сибирийн эрчим хүчний системтэй холбогдсон байна. Заамарын алтны бүлэг шороон ордыг олборлох явцад орон нутгийн чанартай авто замын сүлжээ сайн хөгжсөн ба авто зам нь ердийн ба зарим хэсэгтээ шороон хучилтаар сайруулсан байна. Борнуур-Баясгалантын 110кВт-ын төвийн төвийн эрчим хүчний шугам, 110/6-ийн Баясгалант өртөөнөөс хуваарилан дамжуулах 6-35 кВт ын шугам нь 1.2 км зайтай байрласан байдаг.

Цахилгаан хангамж. “Гурвантамга” ХХК нь “Алтандорнод Монгол” ХХК-ий Дархан-Уул аймгийн цахилгаан түгээх төвийн харьяа Заамар сумын Өгөөмөр багийн Цагаан булгийн “Баясгалант” станцын 110/35 кВ-ийн ерөнхий бууруулах трансформатороос 35/6.3 кВ-ийн өндөр хүчдэлийн агаарын шугамаас цахилгаан эрчим хүчний асуудлаа шийднэ.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ

2025 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсч агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй. Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй.

3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй. Нөхөн сэргээж буй газрыг хүн мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах, Уурхайн эвдэрсэн газрыг нөхөн сэргэсний дараа буй шаардлагатай ургамалуудыг тариалалт хийсний дараа мал, амьтан орж сүйтгэж, үерийн усаар угаагдах зэрэг учирч болох доройтол болон сөрөг нөлөөллүүдээс сэргийлж хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллана.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж:

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:


- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах;
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах;

- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй;
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх;
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх;
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх;
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх;
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх;
- Үржил шимт өнгөн хөрсийг хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах;
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх;
- Үржил шимт хөрсний алдагдал, өгөршлийг бууруулахын тулд хөрсний овоолгыг ургамалжуулах, шимт хөрсийг аль болох богино хугацаанд нөхөн сэргээлтэд ашиглах;
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах;
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах;
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах;
- Талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдэд тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах;
- Барилга, байгууламж байршуулсан хэсэгт үерийн ус зайлуулах шуудуу татах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах;
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана;

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй. Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлсон.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, засгийн газар, БОНХЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “Санжидын ам, Халзангийн ам” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны уулын ажлын байгаль хамгаалах менежментийн биелэлтийн тайланг боловсруулав.



Зураг 2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэгүүд

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар						
Уурхайн олборлолт болон тээвэрлэлтээс тоос босох Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр тоосжилт үүсч агаарын чанар сөргөөр нөлөөлөх	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийв	Нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм;	Мот/цаг, засвар үйлчилгээ	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	<ul style="list-style-type: none"> - Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82
	Уурхайн олборлолт болон тээвэрлэлтээс тоос босох талбайг тогтмол усалж Байсан.	Олборлолт явуулах талбай болон тээвэрлэлти йн зам	Нэгж усалгаа	1,000,000		
	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлж ажиллав.	Уурхайд ашиглагдаж буй замууд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд		
	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлсэн.	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон		
Нийт			1,000,000			
Усан орчин						
Унд ахуйн ус бохирдох	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлсөн	Дотоод үйл ажиллагааны зардалд		Төслийн хугацаанд	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008	
	Хаягдал ус зайлуулах гэрээ болон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах	Дотоод үйл ажиллагааны зардалд				
	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон				
Биологийн олон янз байдал болон ургамлан нөмрөг						

Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	MNS 5916:2008
	Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	Засвар үйлчилгээний талбай		Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	MNS 5917:2008
	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай, авто зогсоол, карьер	-		Төслийн хугацаанд	MNS 5918:2008
Олборлолт болон тээвэрлэлт	Шимт хөрс хуулах талбайн ургамлан бүрхэвчийн мэдээллийг цуглуулах	Төслийн талбай	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан		Жил бүрийн 5 6 сард	Байгаль орчны хамгаалах тухай хууль Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль Амьтны тухай хууль
	Хавар намрын улиралд уурхайн орчмын амьтдад идэш тэжээл, ус зэргийг бэлдэж тавив		-	3,000,000		
Хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаас болж амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхины ноёлох чиглэлийн дор байгуулж, хог хаягдлын ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байв.	Хогийн цэг	-	1,000,000	Үйл ажиллагааны туршид	
Нийт		4,000,000				
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 5,000,000						

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд 2.0 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийнэ. Биологийн нөхөн сэргээлтийг хотхон орчмийн талбайд 0.5 га-д хийсэн.

Техник болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай эвдрэл орохоос урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

✓ Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй.

✓ Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налуугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авлаа.

✓ Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай байв.

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	Техникийн нөхөн сэргээлт	га	2.0	-	11,570,000	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага “MNS 5918:2008”	
Биологийн нөхөн сэргээлт:							
2	Бүрхэвч ургамал тарих	га	0.5	3,200.0	1,600,000		
3	Олон наст ургамлын үр тарьж суулгах	га	0.5	3,200.0	1,600,000		
4	Усалгаа, арчилгаа, тордолт хийх	га	0.5	4,800.0	2,400,000		
5	Шимт хөрс хадгалан, хамгаалах	га	0.5	-	500,000		
6	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	ш	200	-	(Үйлдвэрлэлийн зардалд шингэсэн)		
	Нийт				17,670,000		

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас тогтоож өгсөн газарт өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөсөн байсан. Энэхүү зардалд 3,000,000 сая төгрөг зарцуулав.

Хүснэгт 5. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах төлөвлөгөө	Тоо хэмжээ	Нийт зардал, төг
1	Сумын нутаг дэвсгэрт гар аргаар алт олборлогчдын нөлөөлөлд өртөж эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ	Нөхөн сэргээлт	Аймгийн саналын дагуу гүйцэтгэв.	3,000,000
	Нийт		3,000,000	

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Санжидын ам, Халзангийн ам”-ын алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Заамар сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

9. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үер, аянга цахилгаан буух, шороон шуурга, гал түймэр болох	Байгалийн гамшгийн үед авах арга хэмжээний зааварчилгааг ажилчдад өгөх, аянга цахилгааны газардуулах тоноглолуудын бүрэн бүтэн байдлыг шалгах, орчны тоосжилтоос сэргийлж ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээс хангах	Төслийн талбай	-	1,000,000	Жилд нэг удаа	-
	Гал гарсан тохиолдолд хэрэглэх галын иж бүрдлийн хугацааг шалгаж, сунгуулж байх (Галын иж бүрдлийг байршуулсан болно)	Төслийн талбай	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Жилд нэг удаа	-
	Аянга, цахилгаантай ширүүн бороотой, хүчтэй салхи шуургатай үед гадаах ажлыг түр зогсоох	Уурхайн эдэлбэр газарт	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	
Хүний эрүүл мэнд муудах	Хүний эрүүл мэнд муудахад тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой газар руу нүүлгэн шилжүүлэхийг ажлыг зохион байгуулна.	Уурхайн талбайд		Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, аваар устгах төлөвлөөг дагаж ажиллана.
Автомашинны осол	Тээврийн хэрэгслийн жолоочид Замын хөдөлгөөний аюулгүйн дүрэм болон компанийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч сургалтыг зохион байгуулах.	Уурхайн талбай болон тээврийн зам		Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	
	Байгалийн гамшгийн үед авах арга хэмжээний зааварчилгааг ажилчдад өгөх	Төслийн талбайд		1,000,000	Жилд нэг удаа	
Нийт				1,000,000		

10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэг засвар хийх, хатуу хог хаягдлыг доторжуулах, зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хог хаягдлын цэгт хаях. Хог хаягдлын нэгдсэн байгууламж байгуулах	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль 4, 5, 9, 11, 12, 13, 14, 16, 18, 19, 20, 21, 23, 24-р зүйл MNS5924:2015
		Хог хаягдлын төлбөрөө төлнө.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авсан зардал	500,000	Үйл ажиллагааны турш	
2	Үйлдвэрийн	Уурхайн техникүүдийн засварын цех, мөн уурхайн техникт ашигласан, сольсон тос маслыг сар бүр тусгайлсан савт хуримтлуулсан. Хаягдал техникийн тос, масло хуримтлуулах /сар болгон аюултай хаягдлаа 1 удаа гэрээ хийсэн газарт нийлүүлэх зайлуулах/	500,000	Үйл ажиллагааны турш	
		Уул уурхайн тоног төхөөрөмжөөс гарах нефтийн бүтээгдэхүүний үлдэгдэл хаягдлыг хаягдал зайлуулах газарт шилжүүлэн хаяв.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
Нийт зардал 1,000,000					

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах төлөвлөгөө авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2025 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаар төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтоох зорилготой байв.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаар	Уурхайн дотоод зам, Засварын талбай, уурхайн карьерь	6, 8-р сард	3 цэгт 2 удаа	50,000	300,000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, Хүнд металл тодорхойлох, Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Хөрс	Уурхайн шимт хөрсний овоолго, биологийн нөхөн сэргээлтийн талбай, засварын газар	6, 8-р сард	3 цэгт 2 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 3 цэгт жилд 1 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 25,000 төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45,000 төг <i>Газарзүйн хүрээлэнгийн хөрсний төв лаборатори</i>	210,000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	<ul style="list-style-type: none"> - MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл - MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам - MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээний

3.	Ус	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур	6, 8-р сард	3 цэгт 2 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 50000 төг, Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 141700 төг *УСУГ <i>итгэмжлэгдсэн</i> <i>лабораторийн үнэ</i> Мөн элс угаан баяжуулах нуурын усанд хүнд металлын шинжилгээ өгнө.	1,390,000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар)	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/А/171 тоот тушаалын 2-р хавсралт.
Нийт						1,900,000		

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв төг	Хэрэгжүүлэх хуваарь 2025он	Хариуцсан албан тушаалтан
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төөвлөлтөөр	Уурхайн дарга
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төөвлөлтөөр	“Гурван тамга” ХХК-ийн удирдлагууд
3	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	Үйл ажиллагааны зардалд тусгах	“Гурван тамга” ХХК-ийн удирдлагууд
4	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	Уурхайн дарга
5	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	
6	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Дотоод үйл ажиллагааны зардал	11-р сар	“Гурван тамга” ХХК-ийн удирдлагууд

7	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгав	2,000,000	Дотоод үйл ажиллагааны зардал	“Гурван тамга” ХХК-ийн удирдлагууд
8	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх	Төслийн нийт хугацаанд	Дотоод үйл ажиллагааны зардал	“Гурван тамга” ХХК-ийн удирдлагууд
9	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	Төслийн нийт хугацаанд	Дотоод үйл ажиллагааны зардал	“Гурван тамга” ХХК-ийн удирдлагууд
	Нийт	2,000,000		

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 10. Менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
1	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.	9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.
2		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	11 сарын 1-нд багтаан		
3		Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.	10-р сараас 12-р сарын 1-нд багтаан		

14.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Хүснэгт 11. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д,д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	5,000.0
2	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	1,000.0
3	Нөхөн сэргээлт	17,670.0
4	Дүйцүүлэн нөхөн сэргээлтий зардал	3,000.0
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	1,000.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1,900.0
7	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	2,000.0
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	31,570.0

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд нийт 31,570,000 төгрөг зарцуулагдсанаар тусгагдаж байна.